



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 04

Сангийндалай

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргыг сонгон батлах, ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Тооллогын комиссын дүн мэдээг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанд оролцсон нийт 25 төлөөлөгчөөс 13 төлөөлөгчийн санал буюу нийт санал өгсөн төлөөлөгчдийн 52 хувийн санал авсан Шоовон овогтой Сүхбаярыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгосонд тооцсугай.

2. ИТХ-ын даргын бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон Намчинжав овогтой Чулуунийг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу сумын иргэдийн эрх ашиг, алс хэтийн хөгжлийн зөв бодлогод тулгуурлан удирдан зохион байгуулж ажиллахыг Хурлын дарга (Ш.Сүхбаяр)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ

Н.ГАНСҮХ

